

**ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

“ДБҮЭГ” ТӨҮГ нь 2017 онд үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Төрийн болон болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгон ТӨБЗГ-ын 2016 оны 83 дугаар тогтоолоор баталсан “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын дүрэмд заасан чиг үүргийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Нэг. Байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, түүний үр нөлөөг сайжруулах, удирдлагын үйл ажиллагааг хуульд нийцүүлэх зорилтын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмыг судлан үзэж шинээр болон шинэчлэн баталж, мөрдүүлэх дүрэм журмын жагсаалтыг гарган, шаардлагатай дүрэм журмуудыг шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.

№	Дүрэм журмын нэр	Тушаалын огноо, дугаар	Тайлбар
1.	“Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”	2017.01.04 №А/01	Шинээр
2.	“Хөдөлмөрийн дотоод журам”	2017.02.24 №А/31	Шинэчлэн
3.	“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журам”	2017.09.25 №А/113	Шинээр
4.	“Байгууллагын дотоод хяналт шалгалтын журам”	2017.11.06 №А/124	Шинээр
5.	“Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох, шагнах журам”	2017.12.05 №А/133	Шинээр

Хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, давхардал, хийдлийг арилгах зорилгоор байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрын дүрэм батлах тухай" Засгийн газрын 2016 оны 28 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг, мөн байгууллагын санхүүгийн чадавхийг сайжруулах, үйлчилгээний тарифыг бодитой гарч буй зардалтай уялдуулан тогтоох

зорилгоор ДБҮЭГ-ын үйлчилгээний тарифыг шинэчлэн батлах тухай тушаалын төсөл, танилцуулгыг бэлтгэн ТӨБЗГ-т тус тус хүргүүлээд байна.

Шинээр батлагдсан дүрэм журмын талаар ДБҮЭГ-ын 7 хоног тутмын шуурхай дээр танилцуулж, байгууллагын dipservice.gov.mn цахим хуудас болон дотоод сүлжээнд байршуулж, хэлтэс, албадад цаасаар хүргүүлж, албан хаагчдад танилцуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Бүртгэл, хяналтгүй явж ирсэн гэрээ, хэлэлцээрийг эмхлэн, нэгдсэн бүртгэлийг хөтөлж, хуулийн зөвлөх хянаж, баталгаажуулдаг боллоо.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ДБҮЭГ-ын албан тушаалтны ХАСХОМ-ын 2016 оны тайланг хуулийн хугацаанд нь гаргаж, ТӨБЗГ-т хүргүүлсэн.

Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл гаргасан 62 удаагийн мэдэгдлийг албан хаагчдаас хүлээн авч, мэдэгдлийг програмд оруулсан байна.

Хөдөлмөрийн дотоод журам, ажилтны ёс зүйн дүрмийг зөрчиж, үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандсан 15 албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуульд заасан сахилгын арга хэмжээг авсан.

Хоёр. Хүний нөөц, сургалтын чиглэлээр

Батлагдсан бүтэц, орон тоонд багтаан гадаад томилолтоос ирсэн болон томилогдон явсан, сул орон тоо гарсан албан тушаалд ажилтныг томилох, ажлаас чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан. Тайлангийн хугацаанд ДБҮЭГ-ын Захирлын А тушаал 139, Б тушаал 175 гарч, тушаалын хэрэгжилт 100%-тай байна.

Захирлын 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар Ажилтны ээлжийн амралтыг хуваарийг баталж, нийт албан хаагчдад хуваарийн дагуу ээлжийн амралтыг эдлүүллээ.

Судалгаа: Нийт ажилтны хувийн хэргийн баяжилтийг тогтмол хийхээс гадна албан хаагчдын амьдарч буй орчин нөхцөл, амьжиргааны түвшин, гэр бүл, хаягын судалгааг шинэчлэн авч албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, холбогдох тушаал шийдвэрийг гаргахад ашиглаж байна.

Мөн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үйлчилгээний чанарын судалгааг хагас жил тутамд авч, судалгааны дүнг үндэслэн хоолны цэсийг шинэчлэх, үйлчилгээний албан хаагчдыг ажлын хувцасаар хангах, шаардлагатай

сургалтад хамруулах, үйлчилгээний албан хаагчдын ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, зохицуулалт хийх зэргээр тодорхой арга хэмжээнүүдийг авч ажилласан.

Байгууллагын удирдлага, ажиллагсдын ажлын уялдаа холбоо, хамт олны дундах уур амьсгалд дүн шинжилгаа хийх зорилгоор Удирдах бүрэлдэхүүний талаархи ажиллагсдын судалгааг авч, судалгааны дүнг ТӨБЗГ-т хүргүүлсэн.

Ажиллагсдын нийгмийн асуудал: Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилтын хүрээнд 4 ажилтантай “Орон сууц хөлслүүлэх гэрээ”-г байгуулж, байгууллагын эзэмшлийн байранд хөнгөлөлттэй нөхцлөөр тодорхой хугацаагаар байраар хангаж байна. Ажиллагсдын амьдралын ахуй нөхцөл, нөгөө талаар үйлчилгээнийхээ онцлог байдлыг харгалзан дээрхи шийдвэрийг гаргасан нь аль аль талдаа үр дүнгээ өгсөн ажил болсон. Цаашид 2 айлын орон сууцыг энэ чиглэлээр ашиглахаар засварын ажил хийгдэж байна.

Мөн урсгал засвар хийгдээгүй, эвдэрч орхигдсон “Баянбулаг” зусланд ГХЯ болон өөрийн нийт 20 албан хаагчдын гэр бүлийг гаргаж, тэдний хүч, хөрөнгөөр тодорхой хэмжээний засвар хийлгэсэн нь үр дүнгээ өгсөн ажил боллоо.

Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу **22** ажилтанд гаргасан хүсэлтийг нь үндэслэн нийт **11 350 000** төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон.

Гэр хороололд амьдардаг, өрх толгойлсон болон амьжиргааны түвшингээс доогуур орлоготой **10** ажилтанд хэлтэс, албадаас ирүүлсэн саналыг үндэслэн 11-р сард **25** тонн нүүрсийг үнэ төлбөргүй олгов.

Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цагаан сар болон ахмадын өдрөөр байгууллагын ахмад настнуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн хүлээн авалтын арга хэмжээ зохион байгуулж, гарын бэлэг, мөнгөн урамшуулал олгон, үүнд нийт **13 340 166** төгрөгийг зарцуулсан байна. Мөн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тэгш насны ой нь тохиосон **9** ахмад ажилтанд **1 580 000** төгрөгийн үнэ бүхий дурсгалын зүйл /мөнгөн аяга/ гардуулсан.

Шагнал, урамшуулал, нийгмийн асуудал: Ажил үйлсээрээ хамт олноо тэргүүлж, манлайлсан гавьяа зүтгэлийг үнэлж байгууллагын албан хаагчид болон ахмад ажилтан нийт 28 хүнийг төрийн одон медаль болон салбарын шагналаар шагнуулах санал, холбогдох материалыг ГХЯ болон ТӨБЗГ-т хүргүүлсэнээс 4 ажилтан “Алтан гадас” одонгоор, 1 ажилтан “Хөдөлмөрийн хүндэт” медалиар, 1 ажилтан Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор, 20 ажилтан салбарын шагналаар тус тус шагнагдсан байна.

Ажилтныг урамшуулах, зөв шударга өрсөлдөөнийг дэмжих зорилгоор Захирлын нэрэмжит шагналыг сар тутам олгож байхаар шийдвэрлэсэн бөгөөд уг шагналаар алба, хэлтсээс шалгарсан нийт **49** ажилтныг /давхардсан тоогоор/ шагнаж, нийт шагналд **3 000 000** төгрөгийг зарцуулсан байна.

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх зорилгоор Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээг байгуулж, жил бүр тус эмнэлэгт албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулахаар шийдвэрлэж, ажилтнууд шаардлагатай үедээ тус эмнэлгээр харьяалал харгалзахгүй үйлчлүүлэх боломж бүрдсэн.

Сургалт: ДБҮЭГ-ийн 2017 оны Сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгууллаа. Үүнд:

- “Байгууллагын дотоод харилцааг төлөвшүүлэх хувь хүний хөгжлийн багц сургалт”

- “Баримт бичгийн стандарт, найруулга зүй, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт тухай ойлголт, түүнийг үйлдэж мөрдөх”

- “Ажлын байран дахь бэлгийн дарамт” – Жендэрийн Үндэсний хороотой хамтран,

- “Гэр бүлийн харилцаа” – Гэр бүлийн харилцаа, сэтгэл судлалын үндэсний төвтэй хамтран,

- “Санхүүгийн боловсрол, банкны бүтээгдэхүүн үйлчилгээ” – Голомт банктай хамтран,

- “Харуул хамгаалалт”-ын сэдвээр СБД-ийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэстэй хамтран,

- Хилийн чандад томилолтоор ажиллах жолооч болон техник ажилчдад зориулан англи хэл, харилцааны соёл, дипломат ёс зүй – Дипломат академитэй хамтран,

- Аж ахуйн болон тоног төхөөрөмжийн чиглэлээр,

- Замын хөдөлгөөний дүрмийн сургалт, шалгалт,

- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн, галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх сургалтыг СБД-ийн ОББхэдтэстэй хамтран тус тус зохион байгууллаа.

Бусад: Албан хаагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны уур амьсгалыг төлөвшүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Үүнд:

- 2017 оны 2 дугаар сард "Цасны баяр-2017" арга хэмжээг,
- Олон улсын хүүхдийн эрхийн өдрөөр "Хүүхдийн баяр"-ын арга хэмжээг,
- 9 дүгээр сард Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар үүсэн байгуулагдсаны 66 жилийн ойн баяраар үндэсний цэцэрлэгт хүрээлэнд "Мод тарих" өдөрлөг арга хэмжээг,
- 11 дүгээр сард албан хаагчдын авьяас билгийг нээн илрүүлэх зорилгоор Караоке дууны тэмцээнүүдийг тус тус амжилттай зохион байгууллаа.
- Мөн "Монос" групптэй хамтран "Хаврын Витаминжуулалтын Аян"-ыг ДБҮЭГ-ын хурлын танхимд 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийг албан хаагчдад өгөх ажлыг зохион байгуулсан.
- "Цус сэлбэлт судлалын үндэсний төв"-тэй хамтран "Цусаа бэлэглэе" аяныг 2017 оны 5 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулан нийт 18 ажилтан цусаа өгч, цус хэрэгтэй байгаа нэгний алтан амийг аврахад тусаллаа.
- "Элэг бүтэн Монгол хөтөлбөр"-т албан хаагчдыг хамруулж, элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээг өгч, хариуг албан хаагчдад хүргүүлсэн.

Гурав. Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг Архивын тухай хууль, төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хөтлөн ажиллаа. Архивын баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн, дүрмийг Захирлын 2017 оны А/30 дугаар тушаалаар шинэчлэн баталж, мөрдөн ажилласан.

Хэлтэс албадаас нийт 58 архивын нэгж баримт хүлээн авч данс бүртгэлийг хийж, үүнээс 20 баримтыг үдэж хавтасласан. Архивт байнга хадгалагдах 4 баримтыг скайнердэж PDF файл болгов.

Тайлангийн хугацаанд гаднын байгууллагаас 350 албан бичиг, 28 ноот бичиг ирсэнээс 52 бичигт хариу хүргүүлсэн. ДБҮЭГ-аас 1004 албан бичиг гаднын байгууллагад явсан байна. Шуурхай хурлын тэмдэглэл 40 удаа хөтлөгдсөн.

Мөн 152 өргөдөл ирсэнээс 93 нь шийдвэрлэгдэж, өргөдөл шийдвэрлэлт 61.1 хувьтай байна.

ТӨБЗГ-аас тогтоол шийдвэр хүргүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах тухай, үүрэг даалгавар өгөх, тайлан, мэдээ ирүүлэх тухай зэрэг нийт 41 албан бичгийг

ирүүлснээс хугацаатай, хариутай албан бичгийн хариуг тухай бүр хүргүүлж ажилласан болно.

Дөрөв. Өр авлага барагдуулах чиглэлээр:

2017 оны байдлаар байгууллагын хэмжээнд 51 аж ахуйн нэгж /45 аж ахуйн нэгж, 6 иргэн/-ийн нийт **503 703 238** төгрөгийн өр байна. Эдгээр ААН, иргэнд холбогдох өр, авлага нь хуулийн байгууллагын шийдвэр гарсан боловч түүний хойноос барагдуулах арга хэмжээ аваагүйн улмаас насжилт өндөр, эзэн холбогдогч нь тодорхойгүй, зарим гаднын ААН, байгууллага нутаг буцаж холбоогүй зэрэг шалтгаантай байна. Гэсэн хэдий ч дээрхи байгууллага, ААН, иргэнтэй холбогдож, өр авлагыг барагдуулахаар нэг бүрчлэн уйгагүй ажиллаж байна.

Түрээсийн болон бусад төрлийн өглөгтэй 8 аж ахуйн нэгж, иргэнийг шүүхэд хандаж шийдүүлэхээр харьяа дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан. Дээрх хэрэг маргаанд тухай бүр хариу тайлбар, хүсэлтийг хуулийн хугацаанд гаргаж, шүүх хуралд оролцож ажиллаа.

Тайлангийн хугацаанд 10 аж ахуйн нэгжийн төлбөр буюу **39 598 658** төгрөгийн төлөлт хийгдээд байна. Олон жил хуримтлагдсан дээрх төлбөрийг барагдуулах зорилгоор Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, улсын бүртгэлийн байгууллага, цагдаа, шүүх, шүүхийн архивын байгууллагатай хамтарч ажиллан, хуулийн хүрээнд боломжтой бүхий л арга хэмжээг авч байна.

АСЕМ-ын өр барагдуулах ажлын хүрээнд харьяа дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 11 хуулийн этгээд, иргэнд холбогдох нэхэмжлэлийг гаргаснаас 4 хэрэг маргаан шүүхийн шатанд эцэслэн шийдвэрлэгдэж, бусад хэрэг маргаан шүүхээр шийдвэрлэгдэх шатанд явж байна. Шүүхээр хэрэг маргаан үүсгэснээс хойш **84 250 000** төгрөгийг байгууллагын дансанд төвлөрүүлээд байна. Цаашид графикайн дагуу төлбөр төлөлт хийх 4 аж ахуйн нэгж байгаа бөгөөд 2018 оны 1 дүгээр сар 108 000 000 төгрөгийг төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Тав. Худалдан авалтын чиглэлээр:

Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бараа материалыг худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, худалдан авалтын 2017 оны төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, тайлан мэдээг ТӨБЗГ-т хүргүүлэв.

Жилийн турш холбогдох нэгж, ажилтны захиалгын дагуу 252 удаагийн хүнсний материалын, 194 удаагийн барилгын материалын 48 удаагийн аж ахуйн материалын болон сэлбэг, бусад материалын худалдан авалтыг хийсэн байна.

ДБҮЭГ-аас иргэн, хуулийн этгээдтэй ажил гүйцэтгэх, худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, түрээсийн зэрэг нийт **153** гэрээг байгуулж ажилласнаас гэрээний үүрэгтэй холбоотой маргаан үүсээгүй, гэрээ бүрэн хэрэгжсэн.

Зургаа. Гадаад харилцааны чиглэлээр:

2017 онд байгууллагын гадаад харилцааг хөгжүүлэх, гадаад улсын ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах, харилцаа холбоо тогтоох зорилтыг тавин ажиллаа. Байгууллагын удирдлагууд БНХАУ-ын Бээжин хотын Дипломат үйлчилгээний байгууллагад 6 сарын 26-30-ны өдрийн хооронд ажлын айлчлал хийж, цаашид хамтран ажиллах чиглэлээр санал солилцсон.

Гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, тэдэнд шаардлагатай нийтлэг үйлчилгээг үзүүлэх, дэмжлэг үзүүлэх чиглэлд уулзалт, ярилцлагуудыг зохион байгуулж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.

Монгол Улсад суугаа ЭСЯ-дад үндэсний баяраар нь мэндчилгээ илгээх, ДБҮЭГ-ын албан хаагчдын албан тушаал, холбоо барих утасны дугаар зэрэг мэдээллийг хүргүүлэв.

Хүний нөөцийг хөгжүүлэх, туршлага судлах зорилгоор Сингапур улсын Засгийн газрын тэтгэлэгт сургалтад 2 албан хаагчийг оролцуулсан.

Байгууллагын танилцуулга, брошур болон ЭСЯ-тай хийж байгаа гэрээг англи хэл дээр хөрвүүлэх ажлыг тухай бүр хийж байна.

Долоо. Хэвлэл мэдээллийн чиглэлээр:

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, нээлттэй ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд байгууллагын цахим хуудсын загвар, дизайныг шинэчлэх, мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн оруулж байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу shilendans.mn цахим хуудаст санхүүгийн тайлан мэдээ, бусад хуулийн дагуу мэдээлж байх мэдээллийг тогтмол байршуулж, мэдээллийг оруулах ажилтнуудыг томилон ажиллуулж байна.

ТӨБЗГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу байгууллагын үйл ажиллагааны тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажлын хүрээнд МҮОНТ-ын “Өглөө” хөтөлбөрийн өглөөний зочин, “Өнөөдөр” сонины ярилцлага, NTV телевизийн “Болзоо” нэвтрүүлэгт ДБҮЭГ-ын захирал оролцож, байгууллагын үйл ажиллагаа, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэл өгсөн.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, ГХЯ-нд зохиогдож буй арга хэмжээний тухай нийт 45 мэдээллийг байгууллагын цахим хуудаст оруулсан байна.

Тус газраас үзүүлж байгаа үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, санхүүгийн чадавхийг дэвшүүлэх зорилгоор бүх төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуй нэгж зэрэг 100 гаруй байгууллагад зочид буудал, авто машин түрээсийн үйлчилгээний танилцуулга мэдээллийг албан бичгээр хүргүүлсэн байна.

Байгууллагын фэйсбүүк хуудсаар дамжуулан зочид буудал, зоог хүндэтгэлийн танхимын үйлчилгээний мэдээллийг тогтмол сурталчилж байна. Дипломат зочид буудлын захиалгыг Booking.com цахим хуудсаар авдаг болгосноор гадаад улсаас болон дотоодоос үйлчлүүлэгчдийг татах томоохон арга хэмжээ болсон.

Найм. Дотоод хяналт шалгалтын чиглээр:

Байгууллагын бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, ажлыг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Захирлын 2017 оны А/124 дүгээр тушаалаар “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Журам батлагдсанаар байгууллагын хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдах, ажлын үр нөлөө дээшлэх, хэлтэс, нэгжийн үйл ажиллагааны уялдаа холбоо сайжрах ач холбогдолтой юм.

Дотоод хяналт шалгалтын хүрээнд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, 2017 оны байгууллагын худалдан авалтын төлөвлөгөөний гүйцэтгэлд дотоод хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Ес. Мэдээлэл технологийн чиглэлээр:

Байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад шаардлагатай компьютер, техник хэрэгсэл, програм хангамжийн найдвартай байдлыг бүрэн хариуцан ажилласан. Ажлын байрны аюулгүй байдлыг хангах зорилгоор ДБҮЭГ-ын байрны гадна талд болон Дипломат зочид буудлын 4 давхарт хяналтын камеруудыг суурилуулж, бичлэг хадгалах тохиргоог хийсэн.

Актлагдсан компьютерийн 3 дэлгэц, 2 компьютерийг засаж, ашиглаж байна. Шаардлагатай компьютер, принтерын засвар, тохиргоог хийх, кабель татах зэрэг ажлыг тогтмол хийж гүйцэтгэлээ. Мөн боршур, танилцуулгын эх бэлтгэх, байгууллага дээр зохион байгуулж байгаа арга хэмжээ, хүлээн авалтын техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

Сервер компьютер, дотоод сүлжээний хэвийн ажиллагаанд тогтмол хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа.

Арав. Зоогийн үйлчилгээний чиглэлээр.

Зоог үйлчилгээ: Тус алба нь ГХЯ, ДБҮЭГ-ын зоог, үйлчилгээ, визитийн үйл ажиллагааг зохион байгуулан явуулахын зэрэгцээ ГХЯ-нд болж буй Төрийн болон олон улсын гэрээ хэлэлцээр, уулзалт, хурал, гарын үсэг зурах ёслолын үйл ажиллагаа, хүндэтгэлийн зоог, хүлээн авалт, цай, кофены завсарлага, өдрийн хоолны үйлчилгээ болон бэлтгэл ажлуудад эрүүл ахуйн болон олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж ирлээ.

2017 онд ГХЯ, ДБҮЭГ-т цайны үйлчилгээг нийт 77.000 / албан бус тоогоор / удаа зөрчил дутагдалгүй шуурхай үзүүлж “Их номин” танхимд ГХЯ, олон улсын байгууллагууд болон хамтран ажилладаг төрийн байгууллагуудаас зохион байгуулсан хүлээн авалтуудыг нийт 420 гаруй удаа 11.560 орчим хүн оролцсон ёслол, хүлээн авалтийг алдаа дутагдалгүй олон улсын норм стандартын дагуу үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжинд тулгуурлан хямд зардал бүхий дэвшилтэт хэлбэрүүдийг сонгон үйлчилж ирлээ. Мутрын түшээ танхимд 34 удаагийн оройн зоог, үзэсгэлэн, гарын үсэг зурах ёслолын ажиллагаа, цайны завсарлагууд нийт 2500 хүнд, Зөвшилцөл танхимд зохиогдсон хурал зөвөлгөөн, семинаруудад нийт 82 удаа давтагдсан тоогоор 14.500 орчим хүнд тус тус үйлчлэн зохион байгуулж ирлээ.

ГХЯ “Ёслол хүндэтгэлийн өргөө”-нд 10 давхарт шинэ зоогийн газар тохижуулах техник, тоног төхөөрөмжийн судалгааг боловсруулж гаргасан бөгөөд шаардлагтай төсөвт өртгийг ТЗУГ-тай зөвшилцөж төсвийн тодотголд суулгаж чадсаны үндсэн дээр харьцуулалтын аргаар шалгаруулан тоног төхөөрөмжийг “Тулга техник” ХХК, Тавилга эд хогшилыг “Тайсе-Монгол” ХХК, Эд хогшилыг “Энхмөнхийн Ус” ХХК зэрэг ААН-үүдээс нийлүүлэхээр гэрээ байгуулан эхний ээлжийн тоног төхөөрөмжүүд ирээд байна.

Мөн эрүүл аюулгүй, тэжээллэг, амт чанар бүхий хоолоор үйлчлэхийн тулд эрүүл ахуйчтай хамтран ажиллаж хоолны бараа материал, хагас боловсруулсан бүтээгдэхүүнүүдийг хэрхэн хадгалах сургалт, зөвлөлгөө болон дээж хадгалалтын дэвтэрийг өдөр тутамдаа хөтлөж хэвшээд байна. Тогооч болон визитийн үйлчлэгч нар нь эрүүл ахуйч эмчийн бэлдэж өгсөн амны хаалт, малгай, нөмрөг, түргэн тусламжийн хайрцагыг өдөр болгон ашиглаж хэвшээд байна.

ГХЯ-ны “Их номин” танхим, ДБҮЭГ-ын зоог хүндэтгэлийн өргөөнд шинэ жилийн цэнгүүн зохион байгуулахаар 45,000-75,000 төгрөгийн ханш бүхий 4 төрлийн меню гаргаж 7 байгууллагатай захиалгын гэрээ байгуулаад байна.

Гадаад харилцааны сайдын 57, дэд сайдын 32, төрийн нарийн бичгийн даргын 29 удаагийн, Монгол Улсад суугаа Элчин сайдууд, өндөр дээд хэмжээний зочин төлөөлөгчдийг хүлээн авах уулзалтуудын бэлтгэл ажлыг Дипломат Ёслолын газраас өгсөн чиглэлийн дагуу хангаж ажилласан. Их Номин заал, Мутрын түшээ танхим,

Зөвшилцөл танхимуудад болсон 220 удаагийн хурал, 226 удаагийн кофе завсарлага, 120 удаагийн өдрийн ба оройн зоог, хүндэтгэлийн хүлээн авалт, гарын үсэг зурах, хэвлэлийн бага хурал, хэлэлцээр зэрэг ёслол хүндэтгэлийн арга хэмжээнүүдийн бэлтгэлийг хангаж ажилласан.

Цэвэрлэгээ үйлчилгээ: ГХЯ-ны Ёслол хүндэтгэлийн өргөө, ДБҮЭГ, Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын олон улсын судалгааны төв, Мянганы сорилтын сан, ГХЯ-ны цэцэрлэг, ГХЯ-ны төв архив, ЕХ-ны төсөл, Дипломат хатагтай нарын клуб, Дэлхийн монголчууд ТББ, Дипломат академи, Авто баазын байрны дотор талын нийт 12696 мкв чулуун болон паркетан шал, хивс хивсэнцэртэй өрөө тасалгаа, заал, танхим, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөөнүүдийн цэвэрлэгээ, ГХЯ-ны гадна талбайн 6141 мкв асфальт болон зүлэгжүүлсэн талбайн цэвэрлэгээ, өдөр тутмын цэвэрлэгээ, үйлчилгээ, тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Энэ жилийн хамгийн чухал ажил болох ГХЯ-ны Ёслол хүндэтгэлийн өргөө 2017 оны 10 сард ашиглалтанд орж, нийт 4950 мкв талбайн өрөө, тасалгаа, гадна талбай, дээврийн хэсгийн их цэвэрлэгээг бүрэн бүрэлдэхүүнээр сарын турш хийж гүйцэтгэсэн. Мөн шинэ байрны 9 цайны өрөөнд тавилга угсралтын дараах цэвэрлэгээ, 18 ариун цэврийн өрөөний тохижилтийн ажлыг, 4 сард Төв байрны 8 тоот уулзалтын өрөөг Зоогийн өрөө болгон өөрчлөн тохижуулсан. Гадна талбайн цэвэрлэгээ тохижилтын хувьд 5 сард моднуудыг хэлбэржүүлэн тайрч, гадна талбайд зүлэгжүүлэлт, төв хаалганы хэсгийн мандлыг цэцэгжүүлсэн. Хүйтний улиралд цас, мөсний цэвэрлэгээг тогтмол хийсэн.

Элчин Сайдын Яамдууд, Дипломат Төлөөлөгчийн Газруудын нийт 21 цэгийн хуурай хог хаягдлыг хуваарийн даруу болон нэмэлт дуудлагаар ачиж тээвэрлэж, жилийн байдлаар нийт 804 удаагийн ачилт рейс хийж байгууллагадаа орлого төвлөрүүлж ажилласан байна.

Арван нэг. Засвар үйлчилгээний чиглэлээр.

Тус албаны үндсэн гол үүрэг нь Монгол Улсын ГХЯ, ДБҮЭГ болон түүний харьяа авто бааз, Дипломат зочид буудал, Дипломат 95 цогцолбор, Монгол Улсад суугаа ДТГ-уудын барилга байгууламжуудын ашиглалт, барилга, сантехник, цахилгааны засвар үйлчилгээг хариуцан ажилладаг ба байнгын жижүүрийн утас ажилуулж байгаа бөгөөд холбогдох газруудаас ирсэн дуудлага, хүсэлт, шаардлага бүрийг цаг хугацаанд нь түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.

Тус алба нь 2017 оны жилийн төлөвлөгөөг боловсруулан 62 багц засварын ажил төлөвлөж 38 багц засварын ажлыг төсөвийн дагуу хийж хэрэгжүүлсэн бөгөөд 24 багц ажил нь төсөвтэй холбоотойгоор хойшлогдсон болно. Мөн энэ онд төлөвлөгөөнөөс гадуур ажлууд гарч ирсэн нь 33 багц засварын ажил байгаа бөгөөд эдгээр нь бүгд биелэгдсэн.

Өнгөрч буй онд манай алба дотоодын хүчээр ДБҮЭГ-ын 1-р давхарт байрлах хурлын өрөөг Зоог Хүндэтгэлийн танхим болгон ВИП танхим болон хүлээлгийн танхимын хамт өөрчилж, НҮБ-ын өрөөнүүдийн засвар, БНСВУ-ын арын байрны засвар гэх мэт том засваруудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд гадны гэрээт байгууллагаар НҮБ-ын байрны гадна фассадны засвар, БНСВУ-ын ЭСЯ-ны байрны гадна фассад болон дотор засварууд, Дипломат зочид буудлын их засвар, ГХЯ-ны өрөөнүүдийн засвар зэрэг засваруудыг хийж гүйцэтгэлээ.

Арван хоёр. Харуул хамгаалалтын чиглэлээр.

Харуул хамгаалалтын алба нь ГХЯ-ны архив, ДБҮЭГ, Авто бааз, Дипломат зочид буудал гэсэн 4 тусгай объектыг хамгаалж ирлээ. Манай алба нь нийт 21 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж 2017 онд ажил үүргээ хэвийн сайн гүйцэтгэн зохион байгуулан ирсэн байна.

Харуул хамгаалалтын албаны удирдлага болон Үйлчилгээ ашиглалтын хэлтсийн удирдлагаас тогтмол эргүүл шалгалт хийж тухай бүрд нь үүрэг даалгаварыг өгч хяналт тавин ажилласаар ирсэн.

Бидний гол зорилго нь объектын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж ажиллахаас гадна бусад хэлтэс нэгжүүдтэй уялдаа холбоотой үйл ажиллагааг нь дэмжин ажиллах, гадна дотны зочид үйлчлүүлэгчидтэй зөв боловсон харьцан, байгууллагын дотоод арга хэмжээнд идэвхитэй оролцох зэргийг эрхэмлэн ажиллаж байна.

Харуул хамгаалалтын алба нь 2017 онд хийж гүйцэтгэх төлөвлөгөөт ажлыг биелүүлснээс гадна байгууллагын бусад үйл ажиллагаанд идэвхитэй сайн оролцож ГХЯ, Авто бааз, Дипломат зочид буудлын арын албыг хариуцлагатайгаар гүйцэтгэсэн. Үүний томоохон жишээ нь:

- ГХЯ-ны өргөтгөлийн байрны нүүлгэлт
- ДБҮЭГ-ын хашаанд хүнсний нарийн ногооны хүлэмжний үйл ажиллагаа
- Асем-ийн тавилгын хувиарлалт, хадгалалт
- Дипломат зочид буудлын тохижилт, ашиглалт
- ГХЯ, ДБҮЭГ-ын нээлттэй хаалганы өдөрлөг зэрэг томоохон ажлуудад бүрэн бүрэлдэхүүнээр оролцсон.

Манай хамт олноос байгууллагадаа бага ч гэсэн хувь нэмэр оруулах үүднээс өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан харуулын байрны засвар, цас мөс арилгах цохиур төмөр зэргийг хийж ашиглаж байна.

Мөн харуул А.Мөнхбат нь байгууллагад гарч болзошгүй байсан гадны халдлагыг өөрийн биесийг үл хайхран тэмцэж бусдадаа үлгэр дууриалал болж, албаны нэр хүндийг өндөрт өргөлөө.

Спортийн тэмцээн уралдаанд тогтмол оролцож ширээний теннисний эрэгтэй төрөлд З.Амгаланбаяр 2-р байр эзэлж, сагсан бөмбөгийн баг амжилттай сайн оролцсон.

Бид тухайн объектыг харж хамгаалахаас гадна орчны хог шороо, цас мөсний цэвэрлэгээ мод зүлэг, ногоон бүсийн арчилгаа, усжуулалт зэргийг тогтмол хийж хэвшээд байна.

Арван гурав. Автобааз /автомашинны үйлчилгээ/-ын чиглэлээр

ДБҮЭГ-ын Авто бааз нь Монгол Улсад Төрийн өндөр дээд хэмжээний албан ёсны айлчлал хийж байгаа зочид, төлөөлөгчид болон Монгол Улсын ГХЯ-ны чиглэлээр айлчилж байгаа зочин төлөөлөгч нарт мөн Монгол Улсад суугаа ЭСЯамдын төлөөлөгчид, олон улсын байгууллага болон төрийн бусад байгууллагуудад авто машинаар үйлчилж ирлээ. Манай авто бааз нь нийт 44 алба хаагчдаас үүнээс 4 техник ажилтан, 1 засварчин, 39 жолооч, 45 авто машинтайгаар үйл ажиллагаагаа эрхлэн 2017 онд ажил үүргээ хэвийн сайн гүйцэтгэн зохион байгуулан ажиллаж байна.

Авто бааз нь 2017 онд ГХЯ-ны албан ажилд болон төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээ, дипломат шуудан, шаардлагатай 1836 дуудлаганд, давхардсан тоогоор 1795 жолооч, 1795 авто машин гарч нийт 171 325 км явсан байна. ДБҮЭГ-ын албан ажил болон тус газрын урилгаар ирсэн зочин төлөөлөгч, зоог үйлчилгээ, барилга засвар, хог тээвэрлэлтийн ажилд 260 удаа, шаардлагатай дуудлаганд 1680, 1536 жолооч, 1536 автомашин давхардсан тоогоор нийт 104 529 км явсан. Мөн орон нутаг, ОХУ-ын Улаан-Үд, Эрхүү хотуудад албан томилолтоор ажиллаж техникийн үйлчилгээг цаг хугацаанд нь хурдан шуурхай найдвартай гүйцэтгэж байна.

Ямар нэгэн зөрчил сааталгүйгээр төрийн ёслолын арга хэмжээг зохион байгуулан ажиллаж ирлээ.

2017 оны 2-р улирлаас эхлэн авто баазын авто машин техникийн аюулгүй ажиллагааг хэвийн байлгах, засвар үйлчилгээг тогтоосон хугацаанд нь техник үйлчилгээ ТҮ-1, ТҮ-2, үйлчилгээг хийж нийт давтагдсан тоогоор нийт тээврийн хэрэгслийн 98 хувь нь бүрэн хамрагдсан үзүүлэлттэй байна. Улирал тутмын график хуваарын дагуу авто машинд агаарын шүүр, салон маслын шүүр, шил арчигчын шингэн, дугуй солих зэрэг ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэв.

Засвар үйлчилгээний өдөр тутмын үйлчилгээнд авто тээврийн хэрэгслээс хамаарч чангалгаа тосолгоо, гагнуур, дугуй нөхөх, дугуй солих, эвдрэлээс хамааран тохиргоо хийх, сэлбэг запас солих зэрэг урсгал засвар, техникийн үзлэгээр хөдөлгүүр болон хүч дамжуулах, явах эд анги, тэжээлийн болон хөргөлтийн систем, авто машины өнгө үзэмж, техникийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгадаг ба томоохон хэмжээний айлчлалын үеэр техникийн комиссын акт үйлдэн, гарсан алдаа, зөрчлийг арилгуулах, эрүүл мэндийн үзлэг хийх, жолооч нарт санамж, зөвлөгөө анхааруулга өгч, жолооч авто техникийн аюулгүй байдлыг хангаж ажиллаа.

Авто машины Техникийн аюулгүй байдал, шатахууны зарцуулалтын хяналтыг сайжруулан, аюулгүй ажиллагааны сургалт, заавар, зөвөлгөөг жолооч нарт байнга өгч хэвшүүлээ. Авто баазын хамт олон өөрийн байранд замын хөдөлгөөний аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх , хөдөлмөр аюулгүй байдлын танхим тохижуулан тодорхой сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.

2017 онд шинээр доорхи ажлуудыг хийж гүйцэтгэв.

1. Сургалтын танхим, цай уух өрөөг тохижуулсан.
2. Галын аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор гал унтраагч хор, дохиолол, сурталчилгаа санамжуудыг байрлуулав.
3. Конторын засвар, грашийн дотно талын засвар үйлчилгээг хийлээ.
4. Грашийн дээврийн борооны ус зайлуулах хоолой суурилуулсан.
5. Автомашины засвар, үйлчилгээ хийх зориулалттай өргөгч, тоног төхөөрөмж, Автомат кропны тос солих, тоног төхөөрөмжийг шинээр худалдан авч ашиглаж байна.
6. Жолооч нарыг ажилд дуудах узель шинээр ашиглалтанд орууллаа.
7. Грашийн доторх камеруудыг үйлчилгээ хийлгэн ашиглалтанд оруулав.
8. Төслөөр орж ирсэн Santa Fe 2 ширхэг авто машиныг хөөцөлдөн олж авч ашиглаж байна.
9. Авто баазын авто угаалгын газрыг эмх цэгцтэй болгон ашиглаж байна.
10. Авто баазын гаднах авто машины зогсоолын талбай тохижуулан цэгцэлж шинээр машин зогсох зогсоолын талбайтай болов.
11. Авто баазын хашаанд Нийслэлийн СБД-ийн авто зам, засварын газрын хамт олонтой хамтран борооны усны үерийн худаг суурилуулж, хоолойгоор холбосон болно.
12. Авто баазын хашаанд мод тарьж цэцэрлэгжүүлэв.
13. Авто баазын хашаанд явган хүний зам гаргаж бетондож цутгав.
14. Барилга, сантехник, цахилгааны засварын ажил, цэвэрлэгээ, будаг, шавар, тохижуулах ажлуудыг хийж гүйцэтгэв.
15. ГХЯам, Мянганы ССан, Дипломат академи газруудыг өргөтгөл шинэ барилга руу нүүлгэх ажлыг авто баазын жолооч нарын хамтын хүчээр гүйцэтгэв.
16. Авто грашийн гаднах үүдний хаалгыг засварлаж шинээр хийв.

Авто баазын нийт автомашиныг жолоочийн хариуцлагын болон тээврийн хэрэгслийн даатгал зэргийг /МОНРЕ даатгал/-д бүрэн хамруулсан болно.

Тээврийн хэрэгсэл, авто машинуудыг техникийн улсын үзлэгт бүрэн хамруулж, оношлогоо, автомашины албан татварыг бүрэн төлөв.

Авто баазын жолооч нарын хувцаслалт, ариун цэврийг хангах үүднээс гражийн дотор талд нийт жолооч нарт хувцасны шкафтай болгосон.

Долоо хоногийн 1,4 дэхь өдрүүдэд гражийн дотор талыг 2, 5 дахь өдрүүдэд гадна талбайг өөрсдийн хүчээр бүрэн цэвэрлэж хэвшээд байна.

Мөн ГХЯам, ДБҮЭГ-ын хэмжээнд зохион байгуулагдсан спортын тэмцээнд идэвхитэй бүрэн оролцож байна.

Арван дөрөв. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуйн чиглэлээр.

Байгууллагын дотоод үйл ажиллагаатай уялдуулан нийт ажилчдаа эрүүл, цэвэр орчинд ажиллах нөхцөл бүрдүүлэх, тус байгууллагаас үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчдийн хүнсний аюулгүй байдал, Эрүүл ахуй зэрэгт Монгол Улсад мөрдөгдөж буй хууль дүрэм, Стандартын дагуу хяналт тавьж ажиллахыг эрхэмлэсэн болно.

ДБҮЭГ-ын Захирлын А/113 тоот тушаалын дагуу ДБҮЭГ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуйн дүрмийг ажлын хэсгийн хамтаар боловсруулж, мөрдлөг болгон ажиллахад анхаарч байна.

ГХЯ-ны болон ДБҮЭГ-ын ажилчдын, ГХЯ-ны “Номин” танхим, ДБҮЭГ-ын “Хүндэтгэлийн өргөөн”-нд болсон хүлээн авалтуудад хэрэглэгдэх хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтанд эрүүл ахуйн хяналт байнга тавьж байна.

ГХЯ, ДБҮЭГ-ын гал тогоонд татан авалт хийсэн хүнсний хадгалалт хамгаалалт, хадгалах төхөөрөмжний температурыг шалгах, бүтээгдэхүүний дээж авалт болон авсан дээжний бүртгэлийг долоо хоногт 1-3 удаа шалгаж заавар зөвлөгөө тухай бүрт өгч байна.

ХАБ-ын мэргэжилтэнтэй хамтарч Дипломат буудал, Автобааз, ГХЯ, ДБҮЭГ зэрэгт ажиллах ажлын хуваарь гарган хуваарийн дагуу Эрүүл ахуйн хяналт тавьж ажилласан.

Авто бааз дээр сард 2 удаа болон зайлшгүй шаардлагатай үед дуудлагаар машины ариун цэвэр, жолоочийн эрүүл мэнд, албан хувцаслалт, эрүүл ахуй зэргийг шалган хэвшүүлсэн. Жолооч тус бүр дээр эрүүл мэндийн үзлэгийн хуудас нээж ажиллаж байна.

Зоог үйлчилгээний албаны ажилчдыг эрүүл ахуйн стандартын дагуу, ДБҮЭГ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуйн дүрмийн дагуу хагас жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт оруулж хэвшүүллээ.

ГХЯ, ДБҮЭГ-ын ажлын байр болон гал тогоонуудад мэрэгч, шавьж устгал, халдваргүйтгэл зэргийг эрүүл ахуйн стандартын дагуу хагас жилд нэг удаа хийлгэн, гал тогооны ундны усыг НМХЕГ-ын Лаборатарид жилд 1 удаа өгч шинжлүүлж байгаа ба дүгнэлтээр хэвийн гарсан.

Эмнэлгийн анхны тусламжийн хайрцаг бэлдэн Дипломат буудал, Зоогийн алба, Автобааз дээр байрлуулсан ба эрүүл ахуйн стандартын дагуу эмнэлгийн анхны тусламжийн зүйлүүдийг бэлэн байлгаж шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр:

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний онцлогоос хамаарч ажилдаа тавьсан үндсэн зарчим болон хяналтыг гурван үе шаттайгаар зохион байгуулж ажиллалаа.

1. Хяналтыг хэлтэс, албадад сардаа 1-2 удаа явуулж, шаардлагатай үед алба, хэлтсийн дарга нартай ажлын дундуур хамтран хийж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг анхан шатны хяналтын дэвтэрт тэмдэглэн тэдгээрийг арилгах арга хэмжээг шат дараалан авсан.

2. Хоёр долоо хоногт нэг өдөр /ажлын бус ч өдөр байж болох/ галын аюулгүй байдал болон тус объектод гарч болзошгүй аюулыг олж илрүүлэх, сэргийлэх шалгалтыг Үйлчилгээ ашиглалтын хэлтсийн даргын үүргийн дагуу хийж гүйцэтгэсэн.

3. Шалгалтын дүнг долоо хонгийн шуурхай хурал дээр танилцуулж, аюулгүй ажиллагааны хэм хэмжээг зөрчсөн хүмүүст хариуцлага тооцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг тодорхойлж ажиллалаа.

ХАБЭА хариуцсан зөвлөл байгуулагдсан.

ГХЯ-ны ТЗУГ-ын зөвлөх Базарсад болон Нийслэлийн ОБГ-ын гал түймрийн улсын байцаагч дэслэгч Ц.Барсхүү нартай хамтран яамны хэмжээнд ажилласан.

ГХЯ-ны төв байрны дээврийн хөндийд 60м² нэвчилгээ, гамшиг осол, гал түймэр гарсан үед хүн, эд хөрөнгийг авран гаргах схем зураг гаргах ажлыг ТЗУГ-ын зөвлөх Базарсадтай хамтран зохион байгуулж, стандартын дагуу хяналт тавьж гүйцэтгэсэн.

Аюулгүй байдлын Аваарын гэрэлтүүлгийг ДБҮЭГ-ын оффисс, Дипломат зочид буудал, ГХЯ-ны төв байр болон Консулын хэсэгт байршуулж ажиллагаанд оруулсан.

ГХЯ болон ДБҮЭГ, Дипломат зочид буудал, авто баазын нийт хэрэглэгдэж буй галын хорыг шалгаж, солих ажил хийж, ДБҮЭГ-ын шаардлагатай цэгүүдэд шинээр галын хор байрлуулж, шалгах хуудас болон тэмдэглэгээ хийлээ. Японоос АСЕМ-аар ирсэн галын хорнуудыг хэрхэн ашиглах талаар японы мэргэжилтэнүүд ДБҮЭГ дээр ирж зааварчилгаа өгөв.

ДБҮЭГ-ын ажилтнууд болон авто баазын жолооч нарт гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох сургалтыг 2 удаагийн давталттай СБД-ийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулсан байна. Болзошгүй гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх санамж тэмдэг, гарах орох гарцад ЕХИТ тэмдэглэгээг авто баазын гарааж болон төв байранд байрлуулсан.

Барилгын доторхи усан хангамж, Ариутгах татуурга БНБД 40-05-98 нормын дагуу дотор гал эсэргүүцэх усан хангамжийн системийн дагалдах хэрэгсэл гал унтраах хошуу, хоолой авч байршуулсан байна.

ДБҮЭГ-ын албан хаагч нарт электрон хэлбэрээр Хөдөлмөрийн аюулгүй байдлын “ХАБ-ын тухай ойлголт”, “ХАБ-ын үйл ажиллагаа”, “Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа” болон холбогдох анхан шатны мэдээлэл илгээж мэдээллийн самбар дээр мэдээлэл оруулсан. ДБҮЭГ-ын нийт албан хаагчдад “АНХНЫ ТУСЛАМЖ” сургалтыг СХД-ийн Улаан загалмайн дарга З.Өсөхбаяртай хамтран зохион байгуулсан.

Авто баазд сардаа хоёр удаа хөдөлмөрийн аюулгүй байдал болон галын хор, тэмдэг тэмдэглэл шалгах ажлыг тогтмол хийж механикийн аюулгүй ажиллагааны дэвтэр дээр байнга тэмдэглэл хийж, шинээр орсон жолооч нарт ХАБ-ын анхан шатны зааварчилгааг өгч байна.

Авто баазад автомат гал унтраагуурыг 25м тутамд байрлуулсан .

Дипломат зочид буудлын Галын аюулгүй байдлыг хангах ХАБ-ын шалгалт хийж, тус объектыг үйл ажиллагаанд оруулахад шаардлагатай авах арга хэмжээний жагсаалт гаргаж, галын аюулгүйн гарцын схем бэлэн болгож давхар бүрт байрлуулсан.

Мөн гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, Чингэлтэй дүүргийн ОБ-ын байцагчаар хянуулж, тэмдэг даруулан зочид буудлын үйл ажиллагаа явуулах эрх авлаа.

Арван тав. Зочид буудлын чиглэлээр.

Дипломат зочид буудлын үйл ажиллагааг өөрсдийн дотоод нөөц бололцоог түшиглэн 2017 оны 5 дугаар сард эхлүүлэв. Өнөөдрийн байдлаар зохион байгуулагч-1, ресепшин-3, өрөөний үйлчлэгч-1, угаагч индүүдэгч-1, харуул-3 нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл Дипломат зочид буудал нь 682 ор хоног, 510 зочинтой ажилласан. Зочдын 372 нь гадаад зочин /ГХИГ- 6 зочин, Wind of Mongolia -76, Booking.com -25 ,Номын гүүр-24, Гоо сайхны холбоо-6 зочин, хувиараа-235 / 138 нь Монгол зочин байсан байна.

490 зочинд амт чанартай өглөөний цайгаар үйлчилсэн. Өглөөний цайнд үндсэн 2 төрлийн менюны хоолноос гадна 10 сараас нэр төрлийг олшруулан жимс, нарийн боов, сүү, чацарганы шүүсээр үйлчилгээ үзүүлж байна.

Санхүүгийн чиглэлээр

- 2016 оны аудитын тайлан зөрчилгүй дүгнэлттэй гарсан
- Үндэсний аудитын газрын 2017 оны явцын аудитид санхүүгийн баримт материал шалгуулсан.

- Хэлтсийн жилийн төлөвлөгөөнд сайн үйлсийн аян хийх ажлын хүрээнд байгууллагын гадна талд ахмадуудтай хамтран цэцгийн мандал хийх ажлыг зохион байгуулсан
- ТӨБЗГ-тай хамтран АСЕМ-ийн уулзалт зохион байгуулагдахад БНХАУ-аас тусламжаар ирсэн зочид буудлын тавилга, эд хогшлын холбогдох 10 тогтоол, шийдвэрийг гаргуулсан
- 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тодотголыг хийж, батлуулсан
- Сангийн яамны Хяналт, шалгалтын хэлтсээс зохион байгуулсан 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт шалгалтанд орсон
- 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төсвийн төслийг бэлдэж, анхан шатны ажлын хэсгийн хамгаалалтанд орсон.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын онцлогт тааруулан шинэчлэн батлуулж, дагаж мөрдөхөд бэлдсэн
- Цаг үеийн шинжтэй дээд байгууллагуудаас ирүүлсэн албан даалагаваруудыг бусад хэлтэстэй хамтран гүйцэтгэсэн зэрэг болно.

ДҮГНЭЛТ

2017 онд байгууллагын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ, өнгөрсөн үйл ажиллагааны алдаа дутагдлыг залруулах, зөв менежмент нэвтрүүлэхийг зорин ажиллалаа. Үүний хүрээнд МУ-ын хууль тогтоомж, байгууллагын дүрэм, дотоод журам түүнтэй адилтгах хууль эрх зүйн бусад актын хүрээнд хэлтэс, нэгжүүд үйл ажиллагаагаа төлөвлөн сар тутам дүгнэж, хариуцлагын тогтолцоог бий болгосоноор байгууллагын нэгжүүдийн ажлын чанар, бүтээмжийг дээшлүүлсэн жил боллоо гэж дүгнэж байна.

Учир нь байгууллагын нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирч, ажилчдын идэвхи санаачлага нэмэгдсэний баталгаа нь барилга байгууламж, инженер сантехникийн шугам сүлжээний ашиглалт, авто техникийн засвар үйлчилгээ, зоог визитийн үйлчилгээний талаархи гомдол санал гараагүй, мэргэжлийн байгууллагын шалгалтын дүн мэдээ үүнийг нотлож байна.

Байгууллагын хэлтэс, алба, нэгжүүд өнөөгийн нийгэмд тавигдаж буй дэвшилтэт хэлбэрүүдийг сонгох, олон улсын стандартыг бий болгохыг зорин ажиллах болсон нь мэдрэгдэх боллоо.

Нөгөө талаар ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр анхаарч ажилласаны дүнд Төрийн тусгай албан хаагчдийн эмнэлэгт бүх ажилтан албан

хаагчид үзүүлэх, эмчлүүлэх бололцоо бүрдсэний дээр байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй бодлогийн хүрээнд эрүүл аюулгүй орчинд ажиллах, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, хууль эрх зүйн зөвлөгөө туслалцаанд ажиллагсдын урам зориг, итгэл үнэмшил илт нэмэгдсэн бас нэг чухал зүйл боллоо.

2017 онд батлагдсан төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлэх бодлого менежментийн хүрээнд ажлын чанар бүтээмжийг сайжруулах, үйлчилгээний цар хүрээг тэлж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх өртөг зардлыг бууруулах, барилгын стандарт нормыг хангах, төсөв хэмнэх, хамтрагч төрийн болон олон улсын байгууллага, ААН-үүд, хувь хүнтэй ажил үйлчилгээг хамтран ажиллах гэрээ байгуулан стандарт шаардлага хангасан ёслол, хүлээн авалтийг алдаа дутагдалгүй олон улсын норм стандартын дагуу үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжинд тулгуурлан хямд зардал бүхий дэвшилтэт хэлбэрүүдийг сонгон үйлчилэхийг эрхэмлэж ирсэний дүнд 2017 оны Төрийн Өмчийн шилдэг аж ахуйн нэгж болсон амжилттайгаар хуучин оноо үдэж байна.

Байгууллага 2017 онд өмнөө тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлж:

- Захиргааны хэлтэс – 96 хувь
- Санхүү, эдийн засгийн хэлтэс - 94 хувь
- Үйлчилгээ, ашиглалтын хэлтэс – 93 хувьтайгаар төлөвлөөгөө биелүүлсэн байна.

Зөвшөөрсөн:

ДБҮЭГ-ын захирал

Ё.Нямжав

Хянасан:

Дэд захирал

Д.Хулганажав

Дэд захирал

Д.Чулуунбаатар

Нэгтгэсэн:

Дотоод хяналт, шалгалтын
мэргэжилтэн

Н.Мөнхтуул